

ХЯТАД УЛС ДАХЬ ШАШИН ШҮТЛЭГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ГОЛ ОНЦЛОГ

Цэцэнгуа (БНХАУ)

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын шашин суртахуун урт удаан түүхтэй бөгөөд хятадын гүн ухаан, ёс суртахуун, улс төр, хууль цааз, утга урлаг зэрэг олон хүрээ царгаад гүн шимтэж, өвөрмөц онцлог бүхий шашин суртахууны соёлыг бүрэлдүүлж, нийгмийн амьдрал дөргөн өөрнөлөөлж байна. Эдүгээ Хятадулсад бурханы шашин (үүнд хятад уламжлалтай бурханы шашин, төвд уламжлалтай бурханы шашин, өмнөд уламжлалтай дай үндэстний бурханы шашинг багтааж буй), бумбын шашин (даосын суртал), исламын шашин (лалын суртал), католик шашин, христосын шашин болон цөөн тоот үндэстний шашин шүтлэг зэргээр оршиж, нэг дүндүүр гаруй сүсэгтэнтэй байдаг. Хятад улсын одоох байдал дахь шашин суртахууны хувирал хөгжлийн байдал, түүний гол онцлогийг танин мэдэж, дүндүүр гаруй сүсэгтний үзэл ухамсар, оюун бодлын чиглэл, тэдгээрийн Хятад улс болон түүний хөрш зэргэлдээ олон улсын нийгмийн амьдралд хэрхэн нөлөөлөхийг анхаарч судлах нь олон улсын харилцааны судалгаанд ихээхэн ач тустай юм. Тус өгүүлэлд Хятад улсын шашин суртахууны одоох байдал болон түүний гол онцлогийг дөрвөн зүйлээр тоймлон өгүүлэх болно.

Нэг. Олон зүйлийн шашин суртахуун эв найрамдалтайгаар зэрэгцэн оршиж сэргэн хөгжиж байна.

Хятад улс бол хүн ам олонтой, хятад үндэстэн болон бусад 55 цөөн тоот үндэстнээс бүрэлдсэн олон үндэстэнтэй улс юм. Олон үндэстэн өөр өөрийнхөө соёлын уламжлал болон орон нутгийн байршлаас болж адил бусын шашин шүтлэгтэй байдаг. Хятад үндэстэн голдуу хятад уламжлалтай бурхан шашин болон бумбын шашныг шүтдэг. Төвд үндэстэн төвд уламжлалтай бурхан шашныг шүтэж, баруун хойд оронд суурьшиж байгаа уйгур, хотон, салар, дуншан мэтийн олон үндэстэн исламын шашныг шүтэж, зүүн хойд орны дагуур, эвенки, орчон мэтийн цөөн тоот үндэстэн голдуу бөө мөргөлийн шашныг шүтэж, умард орноор суурьшиж

байгаа монголчууд голдуу төвд уламжлалтай бурхан шашин болон бөө мөргөлийн шашныг шүтдэг. Хятадын дундад орон, дорнод орон болон өмнөд оронд христосын шашин дэлгэрч байна. Эдгээр шашин суртахуун нь номлол сургаал, ёс дүрэм, сүм хийд, сүсэгтэн зэрэг олон талаар цөм тус тусдаа байгаа боловч адил нэгэн газар оронд нэг нэгэндээ харшил гэмгүйгээр зэрэгцэн оршиж, эе найрамдалтайгаар зохицон харилцаж байдаг. Энэхүү байдал БНХАУ байгуулагдсанаас наашхи жар гаруй жилийн дотор үргэлжилсээр ирсэн юм. Иймэрхүү эл төрлийн шашин суртахуун хоорондоо номлол сургаалын маргалдаангүй, сүсэгтэн хоорондоо их хэмжээний хурцширүүн мөргөлдөөн гарсангүй. Урт хугацаагаар зэрэгцэн орших байдал дэлхийн шашин суртахууны хөгжлийн түүхээс авч хэлсэн ч ховорхон байдаг юм. Хятад улсын олон зүйлийн шашин суртахуун эв найрамдалтайгаар зэрэгцэн оршиж, тус тусын хөгжил цэцэглэлээ олж байгаа байдлын буй болсон нь Хятад улсын засгийн газраас авч байгаа шашин суртахууны төрийн бодлого, өөрчлөлт хийж чөлөөтэй харилцах болсноос наашхи эдийн засгийн хөгжил, эл төрлийн шашин суртахууны номлол сургаалд өөрчлөлт тохируулалт хийсэн зэргээс шалтгаална.

БНХАУ байгуулагдсаны дараа Хятад улсын коммунист намын төв хороо болон засгийн газраас бүх улсын хэмжээнд шашин шүтлэгийн эрх чөлөөтэй байх төрийн бодлого явуулж, шашин шүтлэгийн асуудалд хянуур болгоомжтой бөгөөд тогтуун баттай арга хэмжээ авчээ. 1954 онд болсон анхдугаар удаагийн бүх улсын ардын төлөөлөгчдийн их хурлаас баталсан "БНХАУ-ын үндсэн хууль"-ийн 88-р зүйлд: "БНХАУ-ын иргэн шашин шүтлэгийн эрх чөлөөтэй" гэж тогтоосон байна. Ингэснээс шашин шүтлэгийн эрх чөлөөтэй байх нь Хятад улсын нэгэн чухал төрийн бодлого болсон байна. 1957 оноос хойш Хятад улсын шашин шүтлэгийн ажилд "зүүн"-ий алдаа гарч, "соёлын хувьсгал"-ын үед шашин шүтлэгийн эрх чөлөөтэй төрийн бодлого эвдэгдэж, шашин шүтлэгийн хэвийн ажиллагаа хориглогдож, шашны удирдагч болон сүсэгтнүүд адил бус хэмжээний аюул хөнөөлд учирсан юм. "Соёлын хувьсгал" өнгөрч, өөрчлөлт хийж чөлөөтэй харилцах болсноос нааш, шашин шүтлэгийн эрх чөлөөтэй төрийн бодлого сэргэж, шашин суртахууны ажиллагаа хэвийн байдалд орсон бөгөөд өөрийн хөгжлөө олсон байна.

1982 онд Хятадын коммунист намын төв хорооноос "Шашин шүтлэгийн эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах бол манай намын шашин суртахууны асуудалд хандах урт хугацааны төрийн бодлого болно. Энэ бол ард түмний ашиг тусад нийцэх цорын ганц зөв оновчтой төрийн бодлого юм. Шашин шүтлэгийн эрх чөлөөтэй гэх бол БНХАУ-ын иргэн нэг бүр шашин шүтэх эрх чөлөөтэй, мөн ч шашин шүтэхгүй эрх чөлөөтэй. Аль нэгэн шашныг шүтэхээ сонгох эрх чөлөөтэй. Нэг зүйлийн шашны дотроос аль нэгэн урсгал бүлэг номлол сургаалыг нь шүтэх тухай сонгох эрх чөлөөтэй. Шашин шүтэхгүй байснаас шүтэж болох эрх чөлөөтэй, шүтэж байснаасаа шүтэхээ болих эрх чөлөөтэй" гэж тогтоожээ¹. Мөн тус жилд "БНХАУ-ын иргэн шашин шүтлэгийн эрх чөлөөтэй, ямарваа төрийн байгууллага, нийгмийн бүлгэм болон хувь хүнээс ард иргэдийг шашин шүтүүлэх буюу үл шүтүүлэх гэж албадаж болохгүй. Шашин шүтдэг иргэн буюу шашин үл шүтэх иргэнийг гадуурчилж болохгүй" гэж үндсэн хуульд тодорхой тогтоожээ². Энэ нь шашин суртахууны сэргэн хөгжихөд улс төр, хууль цаазын баталгааг хангажээ.

XX зууны наядад оноос эхэлж, Хятад улс өөрчлөлт хийж, чөлөөтэй харилцах төрийн бодлого явуулснаар эдийн засаг түргэнээр хөгжиж, шашин суртахуун соёлын хөгжилтийг ихээр ахиулжээ. Эл орны засгийн газраас их хэмжээний бэлэн мөнгө гаргаж, сүм хийдийг засан сэлбэсэн буюу дахин байгуулсан. Өвөр монголын өөртөө засах орны жишээн дээр хэлбэл, XX зууны наяд оны үед нийт 1500 түмэн юан зарцуулж, эл аймаг хотын сүм хийдийг сэлбэн зассан байна. XX зууны ерээд оны үед 700 түмэн юан гаргаж, Бугатын Бадгар зуу, Ордосын Зүүнгар зуу, Алашаагийн өмнө хийдийг засан сэлбэсэн байна. 2000 оноос эхлээд, төвд уламжлалтай бурхан шашны сүм хийдэд жил бүр 00 түмэн юаны сэлбэн засах мөнгө өгөх болсноос 2004 оноос эхлээд жил бүр 300 түмэн юан болгон өсгөж, эдүгээ болтол өгсөөр байгаа юм³. Эдийн засгийн хөгжлөөс болж сүсэгтэн шашин шүтлэгийн учирт их хэмжээний мөнгө зарцуулах болсон юм. Шинжааны уйгур үндэстний мусульманчуудын дундаас 20 түмэн юан зарцуулж, Меккад мөргөл хийхээр явсан хүн, XX зууны наяд оноос нааш эдүгээ болтол 5 түм илүү буй⁴. Хятад уламжлалтай бурхан шашны сүсэгтэн өөрөө мөнгө зарцуулж, суварга

босгож, сүм байгуулж байгаа хүн ч олон байна. Үүнээс гадна, эл төрлийн шашин суртахууны сүм хийд нь аялал жуулчлалын газар болж, олон тооны жуулчдыг хүлээн авч тойрон үзүүлж, их хэмжээний орлого олдог.

3. Эл төрлийн шашин суртахууны номлол сургаал нь шинэ цаг үеийн байдалтай зохицохын төлөө зохих хэмжээний өөрчлөлт тохируулалттай болжээ. Үүнийг дараах хэсэгт нарийн тоочье.

Эдгээр гол шалтгаанаас гадна бас олон олон нөхцөл боломжоос болж, Хятад улсын шашин суртахуун ихээр сэргэн хөгжиж, эдүгээ эл төрлийн шашин суртахууны сүсэгтний тоо нэг дүнчүүр гаруй болжээ. Түүний дотор, христосын үсэгтэн 1000 түм гаруй байж, орчмын 20 гаруй жилийн өсөлтийн тоо нь өнгөрсөн 300 гаруй жилийн өсөлтийн тооны хэд дахин болж байна. Католик шашны сүсэгтэн 400 түм гаруй болж, 1949 оны бүртгэлээс 100 түм илүү болжээ. Исламын шашны сүсэгтний тоо нь 1800 түм гаруй байдаг⁵. Бурхан шашин олон бумбын шашны сүсэгтний тоо нь оновчтой бүртгэлгүй боловч, хятадын уламжлалт шашин суртахууны хувьд ихэнх тоог эзэлж байдаг.

Хоёр. Олон зүйлийн шашин суртахууны номлол сургаалд өөрчлөлт тохируулалт гарч, Хятад улсын одоох байдалтай зохицож байна.

Шашин суртахууны номлол сургаал бол шашин соёлын гол цогц юм. Олон зүйлийн шашин суртахууны хоорондоо ялгагдах онцлог нь ч шашин суртахууны номлол сургаал нь адилгүйгээс болсон юм. Шашин суртахууны хөгжлийн түүхээс үзвэл, шашны номлол сургаал нь хэдийгээр тогтмол бөгөөд өөрийн дотоодын хөгжлийн замаар уламжилж байдаг боловч өнөд хувиралгүй үхмэл ёс биш юм. Тэр нь нийгэм орчны хувиралтыг дагалдан хувирч байдаг бөгөөд шашин суртахууны өөр биеийн оршин тогтнох болон хөгжлийн шаардлагаас болж зохих хэмжээнд өөрчлөлт тохируулалт гардаг. БНХАУ байгуулагдсаны дараа, эл төрлийн шашин суртахуун социалист нийгмийн улс төр, эдийн засаг, үзэл ухамсар соёлын талаар зохицохын төлөө өөр өөрийн шашны номлолын үндэслэл дээр зохих хэмжээний өөрчлөлт хийж, шинэ агуулга нэмж оруулсан байна. Хятад улсын христосын шашны төлөөлөгч Ву яо зүн

гуай 1949 оны 7 сард "Да Гүн сонин" дээр "Христосын сүсэгтний өөрчлөлт" гэдэг зохиол нийтэлж, "шашин шүтлэг болон шашны үзэл санаа бодитой нийгмийн байгуулал болон нийгмийн орчин ахуйн нөлөөнөөс зайлсхийж чадахгүй юм" хэмээн үзэж, христосын шашны номлолд өөрчлөлт хийхийг анаачлан дурдаж, христосын сүсэгтнийг есүсийн сургаалыг өөрсдөө ухааран мэдэж, бодит амьдралын үнэн ахуйгаас зайлан дутаах үзэл санааг тэвчээрэй гэж уриалан, хятадын онцлог бүхий христосын номлол сургаалыг үүджээ.

"Тэнгэрийн салхи" хэмээх христосын шашны сэтгүүл дээр "Христосын сүсэгтэндэлхий ертөнцийг хэрхэн танивал зохистой вэ?" гэдэг сэдвээр судлан ярилцах бүлэг гаргаж, шүтээний тухай олон асуудлыг ярилцаж, христосын уламжлалт номлол сургаалд шинэ тайлбар хийж, өөрчлөлт тохируулалт оруулсан байдаг. Жишээлбэл: Уул номлолд дэлхий ертөнц чөтгөр шуламд эрхшээгдэж, ял нүглээр дүүрэн байдаг. Гагцхүү христосын шашны нийгэмлэг л ариун дархан байдаг гэж сурталчилж байсныг судлан ярилцсаны эцэст, дэлхий ертөнцийг хурмаст тэнгэр үүдэн бүтээж эрхшээн хамаарч байдаг. Хүн төрөлхтөн төв голч шулуун шударга байх нь хурмаст тэнгэрийн санаанд нийцэх юм гэж өөрчилжээ. урхан шашны номлолд хүн төрөлхтөний энэ төрлийн амьдралд хүчир зовлонгоор дүүрч, аливаа бүхэн ер бусын байдаг. Хэрвээ ашдын зол жаргалыг эдлэе гэвэл энэ төрөлдөө буян үйлдэж, хойд төрөлдөө төгс жаргалант оронд заяахыг даатгах хэрэгтэй гэсэн үзэл санаа байдаг. Энэ нь нэг хэмжээгээр хүний бодит амьдралын утга агуулгыг үгүйсгэж, хүмүүсийг бодит амьдралд назгайгаар хандах овор сурталтай болгодог юм. БНХАУ байгуулагдсаны дараа, социалист нийгмийн байдалд зохицуулахын төлөө, хятадын бурхан шашны нийгэмлэгийн дарга Юан Ин багш "Хүний ертөнцийн бурхан шашин" гэдэг үзэл санааг дурдаж, бурхан шашны сүсэгтнийг "Улс орноо бүтээн байгуулах үйлст зүтгэж, ард түмэнд үйлчилсүгэй" гэж уриалсан байна. Бурхан шашны алдарт эрдэмтэн Шаравжамц тусгайлан зохиол бичиж, бурхан шашны сүсэгтнийг "Хүний ертөнцийн төгс жаргалант орныг бүтээн байгуулахаар эмцсүгэй" гэж шаардсан байна. Исламын шашин "урьд төрөлд тогтоосон" ба "хойд төрлийн тавилан" гэж сурталчлан,

хүний амьдралын аливаа бүхнийг цөм "Аллах"-аас урьдчилан тохируулсан юм гэж номлож, "Дэлхий ертөнцийн мөхөл хүрч ирнэ" гэж сурталчилж байжээ. БНХАУ байгуулагдсаны дараа мусульманчуудыг социалист нийгмийн байдалд зохицуулахын төлөө исламын шашны төлөөлөгчөөс шашны номлолдоо шинэ тайлбар хийж, "Хүний амьдралын зол жаргалыг Аллахад даатгахын хамт өөрийн хатуужилтай хөдөлмөрөөр тэмцэн олж болно. Иймээс бодит амьдралаа бүтээн байгуулахаар чармайя" гэж уриалсан бөгөөд "Дэлхий ертөнцийн мөхлийн өдөр"-ийг сурталчлахаа больжээ. Ерөнхийд нь үзвэл, Хятад улсын одоох байдал дахь шашин суртахууны номлол сургаалд өөрчлөлт тохируулалттай болсон нь голдуу доорх хоёр талаар тусгагдаж байдаг. Үүнд: Нэг нь уламжлалт номлол дахь зарим агуулгыг өөрчилж, "тэнгэр дээрх ертөнц"-ийн жаргалыг хөөцөлдөхийн хамт бодит ертөнцийг ч хүндэтгэн үзэж, хүн болон сахиусны амьдралыг нэгтгэхээр оролджээ. Нөгөө нь шашин суртахууны номлолыг дахин шинээр тайлбарлаж, зохих хэмжээний нийгмийн ёс суртахууны агуулгыг нэмэн оруулжээ. Энэ нь шашин суртахууныг социалист нийгмийн улс төр, үзэл ухамсар, нийгмийн эмхдэглэмд зохицуулахын төлөө хийсэн оролдлого болно.

Гурав. Олон зүйлийн шашин суртахуун уламжлалт ёслол дүрмээ үндсэндээ хадгалж байна.

Хэдэн арван жилийн турш, Хятад улсын олон зүйлийн шашин суртахуун социалист нийгэмтэй зохицохын төлөө өөр өөрийн номлол сургаалдаа өөрчлөлт тохируулалт хийсэн боловч уламжлалт ёслол дүрмээ үндсэндээ хадгалж, сүсэгтний шашин шүтлэгийн итгэл бишрэл, хайр сэтгэлгээ болон зориг цөсийг чангатгахын дагуу шашин шүтлэгийн үйл ажиллагааг дүрэмжүүлж, шашин суртахууны зохион байгуулалтыг бэхжүүлж, шашин суртахууны нөлөө тусгалыг өргөтгөж байдаг.

Бурхан шашны уламжлалт ёслолд, бурханд мөргөх, ном унших, сахил санваарыг сахих, номын хурал хийх, цам харайх зэрэг байдгаас гадна, бурхан багш Шагжамүнийн мэндэлсэн өдөр, будда болсон өдөр, нирван дүр үзүүлсэн (таалал төгссөн) өдөр зэргийг тэмдэглэх ёслол байдаг. Бумбын шашны

уламжлалт ёслолд ном унших, урт наслахыг ерөөн даатгах, өглөг өгөх, цэцэг цацах, тэнгэр тахих, гамшиг арилгаж, буян гуйчлах зэрэг олон зүйлийн ёслол дүрэм байдаг бөгөөд өдөр бүр биеийн тамирын дасгал хийдэг. Үүнд тэнгэрийн сахиус, лусын сахиус, газрын сахиус, од гаригийн сахиус зэрэг олон сахиуст тахилга өргөх, тэдний мэндэлсэн өдрийг дурсан тэмдэглэх, тэнгэрийн сахиусыг угтах зэрэг том хэмжээний ёслол нь билгийн улирлын шинийн нэгэн, арван тавны өдөр явагддаг. Исламын шашны уламжлалт ёслолд угаал хийх, коран судар унших, алахад мөргөх зэрэг байдаг. Сүсэгтний өдөр тутмын идэж уух, явж суух талаар ч исламын шашны дүрмээр чанга шаарддаг. Католик шашин, христосын шашны сүсэгтэн гарагийн өдөр болгон христосын сүмд ариун ном унших, есүсийн магтаал дуу дуулах, залбиран даатгах зэрэг ёслол явуулж байхаас гадна, жил бүрийн есүсийн мэндэлсэн өдөр, дахин амилсан өдөр зэрэг баяр дурсгалын өдөрт томоохон хэмжээний ёслол явуулдаг.

Хятад улсын шашин суртахууны эл зүйлийн ёслол явуулах үйл ажиллагаа нь хуулийн дагуу явагдаж, сүсэгтний эрх ашгийг хамгаалсан урьдал доор өөрийн чанга нямбай дүрэм тогтоолоо хэрэгжүүлж буй.

Дөрөв. Олон зүйлийн шашин суртахуун урт хугацаагаар орших боломж байна.

Шашин суртахууны өөрийн уламжлалаас болж, Хятад улсын олон зүйлийн шашин суртахуун урт хугацаагаар орших боломжтой юм. Хятад уламжлалтай бурханы шашин, бумбын шашин болон Күнзийн сургаал холилдон уялдаж, хятадын уламжлалт соёлын гол бүрэлдэхүүн болж, хятад үндэстний оюун сэтгэхүй, зан заншил, нийгмийн харилцаанд хүчтэй нөлөөлж байдаг. Хятад үндэстэн төвлөрөн сууж байгаа хедөө тосгонд чөтгөр шулам болон сахиусны итгэл бишрэл бас нийтлэг оршиж, өрх бүхэн үүдэн сахиус, зуухын сахиус тахиж байдаг. Цөөн тоот үндэстний газар оронд шашин суртахууны уламжлал нэн чанга хүчтэй байдаг. Төвд, монгол, уйгур, хотон зэрэг хязгаар орны цөөн тоот үндэстний үр хойч, хар багаасаа гэр бүл болон амьдралын орчин тойрны нөлөөнөөс болж, өөрийн уламжлалт шашин шүтлэгийнхээ чин үнэнч сүсэгтэн болж хүмүүждэг. Бөө мөргөлийн шашин шүтэж байгаа гуч гаруй цөөн тоот үндэстэн ч уламжлалт соёл болон амьдралын

зан заншлаа урт хугацаагаар хадгалж, үе улиран уламжилдаг юм.

Хятад улсын олон зүйлийн шашин суртахуун урт хугацаагаар оршихын бас нэгэн гол шалтгаан гэвэл, одоогийн дэлхий нийтийн даяарчлал (глобалчлал)-ын урсгалд Хятад улсын шашин суртахуун болон харь улсын шашин суртахууны харилцаа олширч, өргөн хэмжээний солилцоотой болж, шашин дэлгэрүүлэх ажил улмаас улам дөхөм болжээ. Үүний үр дүнд, харь улсын шашин Хятад улсад улам олон сүсэгтэнтэй болж байна. Америкийн сурвалжлагч Давид Алкманы төсөвлөснөөр ирээдүйн 30 жилийн дотор, Хятад улсын хүн амын 20 хувь нь христосын сүсэгтэн болж, христосын шашин Хятад орны гол шашин болно гэжээ⁶. Үүнээс гадна, уламжлалт шашин шүтлэгтэй төвд, уйгур зэрэг цөөн тоот үндэстэн болон хилийн гаднах төвд, уйгар зэрэг үндэстний хоорондох соёлын харилцаа улам нягтарч, шашин шүтлэгийн хүрээ хэмжээнд улам илүү харилцаатай болж байна.

Хятад улсын нийгмийн байдлаас үзсэн ч шашин суртахуун урт хугацаагаар оршин тогтнох нөхцөл боломжтой байдаг. "Шашин суртахуун оршин тогтнохын хамаг гүн үндэс сурвалж бол ядуу хоосон болон сохор балай болох юм"⁷ гэдэгчлэн, Хятад улсад соёл боловсролын хэмжээ доор буюу соёлын балай (үсэг танихгүй хүн) хүний тоо их болж, ядуу хоосрол, ажилгүйдэл, ураг гэр бүлийн сүйрэл, эрүүл мэндийн сүйдэл зэрэг хүний амьдралд сөхрөх нөлөө үзүүлдэг асуудлууд оршиж байгаа тул шашин суртахуун урт хугацаагаар орших нийгмийн обьектив ахуй болон шалтгаан болж болдог. Байцаалтыг үндэслэвэл, Хятад улсын ядуу хоцронгуй газар орны сүсэгтний тоо нь баялаг газар орны сүсэгтний тооноос олон, тариачны доторх сүсэгтний тоо нь сэхээтний доторх сүсэгтний тооноос олон, соёл боловсролын хэмжээ доор сүсэгтний тоо нь соёл боловсролын хэмжээ өндөр сүсэгтний тооноос олон байдаг.

Хятад улсын засгийн газраас шашин суртахууны урт хугацаагаар орших боломжийг гүйцэд анхаарч, "Шашин

суртахууны ажлын үндсэн үүрэг бол Марксын үзлийн зогсолт, үзэлт, аргыг баримталж, социалист нийгэмд шашин суртахуун урт хугацаагаар оршин тогтнох объектив байдлыг таньж, шашин суртахууны дотоод жам хуулийг эзэмшихээр чармайж, шашин суртахууны ажлын хэр түвшнийг дээшлүүлж, шашин суртахууны төлөөлөгч хүн болон өргөн олон сүсэгтэнтэй бүлгэмдэж, хятадын онцлог бүхий нийгэм журамт үйлсийн хамтын харалтын төлөө тэмцье" гэж уриалж, "Шашин суртахууны хэрэг явдлыг хуулийн дагуу хамаарч, олон зүйлийн шашин суртахууны хооронд харилцан хүндэтгэх, харилцан суралцах, эе найртай харилцаатай болохыг ахиулна" гэж дурджээ⁸.

Ерөнхийд нь авч хэлбэл, Хятад улс өөрчлөлт хийж, чөлөөтэй харилцах төрийн бодлого хэрэгжүүлснээс нааш, олон зүйлийн шашин суртахуун сэргэн хөгжсөн байдалд орж, коммунист нам болон засгийн газраас дурдсан "Шашин суртахууны этгээд заавал хууль цаазын эрх сүрийг хамгаалах, ард түмний ашиг тусыг хамгаалах, үндэстний бүлгэмдлийг хамгаалах, улс орны нэгдлийг хамгаалах зэрэг үндсэн зарчмыг баримтлах хэрэгтэй" гэсэн шаардлагаар өөр өөрийн дүрэм ёслолоо явуулж, нийгмийн соёлын амьдралын хүрээ хэмжээнд чухал үйлдэл гаргаж байна.

ЗҮҮЛТ

- ¹ Нийгэм журмын цаг үеийн шашин суртахууны асуудлын үндсэн үзэлт ба төрийн бодлого. "Нэгдмэл фронтын 100 асуудлын тухай". Төвийн нэгдмэл фронтын хэлтсийн судлах газар. Хуавэн хэвлэлийн хороо. 2010. 217 дугаар нүүрт. 《关于我国社会主义时期宗教问题的基本观点和基本政策》, 《统一战线 100个由来》, 中央统战部研究室编者, 华文出版社 2010年, 217页。
- ² 1982 онд хуралдсан тавдугаар хугацааны Бүх улсын ардын төлөөлөгчдийн их хурлын тавдугаар удаагийн хурлаас баталсан "Бүгд Найрамдах Хятад Ард Улсын үндсэн хууль"-ийн 36 дугаар зүйл
- ³ Гэрэлт, Сү Юншэн. "Өвөр монголын малжих орны шашин суртахууны хувирал". Энх, Эрдэнэжавын найруулсан "Өвөр монголын малжих орны нийгмийн хувирлын

- судлал". Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо, 2011. 212 дугаар нүүрт.
- ⁴ "Нэгдмэл фронтын гарын авлага". Төвийн нэгдмэл фронтын хэлтсийн судлах газар. Хуавэн хэвлэлийн хороо, 2011. 178 дугаар нүүрт. 《统一战线实用工作方法》中央统战部研究室编者, 华文出版社, 2011年, 178页。
- ⁵ Е Сяовэнь. "Хятадын шашин суртахууны 100 жилийн эргэцүүлэл ба тойм". У Янмин "21 дүгээр зууны шашин суртахууны төлөв" Хонконг. Вэншин хэвлэлийн компани. 2001. 42 дугаар нүүрт. 叶小文: 《中国宗教的百年回顾与前瞻》, 吴样明: 《二十一世纪的宗教展望》, 香港, 文星图书有限公司, 2001年, 42页。
- ⁶ David Alkman. *Jesus in Beijing: How Christianity is Transforming China and Changing the global Balance of Power*, Regnery Publishing, Inc, Washington, DC, 2003. pp.285.
- ⁷ Лениний бүрэн зохиол. Ардын хэвлэлийн хороо. 1963. 28 дугаар боть. 163 дугаар нүүрт.
- ⁸ Жу Вэйчунь. "Шинэ эриний нэгдмэл фронтыг бэхжүүлэн хөгжүүлэх тухай". "ХКН-ын 18 их хурлын тайланг унших бичиг" Ардын хэвлэлийн хороо. 2012. 214 дүгээр нүүрт. 朱维群: 《巩固壮大新世纪新阶段爱国统一战线》, 《十八大报告辅导读本》, 人民出版社, 2012年, 241页。

Abstract:

There are more than one hundred million religious believers of Buddhism, Taoism, Islam, Catholicism, Protestantism and minority nationality religion in current China. Study the characteristics and development trend of current Chinese religion has important practical.

Significance to the China's social harmony and stability and friendly relationship between neighboring countries. This article analyzed the main characteristics of current Chinese religion about presents a variety of religious and coexistence, religions to adapt themselves to the socialist society, religious ritual remained intact, social causes of religious long-standing.

Keywords: *Chinese religion, Coexistence, Long-standing*